

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА

Сурвалж

/Я.БОЛДБААТАР/

2017 оны 5 дугаар сарын 29.

БАТЛАВ

"ХҮСЛЭМЖ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

/Д.ГАНЗОРИГ/

2017 оны 5 дугаар сарын 29.

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар 20

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын Усны тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу "Монгол-Ус" ТӨҮГ-ын захирлын "Дүнгэлт хүргүүлэх тухай" 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 166 тоот, Туул голын сав газрын захиргааны даргын 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн А-34 тоот тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Ус ашиглалтыг - зохицуулах албаны уул уурхай, эрчим хүчиний ус ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн С.Сүхбат, Ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 14-р хороо, 3-р хороолол, 10-11 тоотод байрлах, улсын бүртгэлийн 9011025122 тоот гарчилгээ, 2872722 тоот регистрийн дугаартай "Хүслэмж" ХХК-ийн захирал Д.Ганзориг нар ус ашиглах талаар тохиролцож энэхүү гэрээг 2017 оныг дуустал байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Булган вимгийн Бүрэгхангай сумын нутагт орших MV-020512 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Туулын зүүн дэнж"-ийн алтны шороон ордын талбайд үйлдвэрлэлийн технологийн хэрэгцээнд Туул голоос ус ашиглана.

2.1.1. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын Сайдын 2014 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн A05 дугаар тушаалаар баталсан "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 3.3-т заасны дагуу 2017 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах ажлын хэсэгт Туул голын сав газрын захиргаанаас төлөөлөл оролцуулж, дүгнэх хуудсыг баталгаажуулна.

2.2. Нийт ашиглах усны хэмжээ: 72'908 м³ элс угаахад зарцуулах ус 291'632 м³/жил

2.2.1. Үнд-ахуйд: 4095 м³/жил

2.2.2. Үйлдвэрлэлд нөхөн сэлбэлтээр ашиглах усны хэмжээ: 90'240 м³/жил

2.2.3. Зам, талбайн усалгаанд шаардагдах ус: 4680 м³/жил

2.3. Усны чанар, найрлага: 2017 оны 7, 9 дүгээр саруудад хаягдлын нуурнаас усны дээж авч итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэн, шинжилгээний дунг Туул голын сав газрын захиргаанд ирүүлнэ.

2.4. Усны эх үүсвэр:

2.4.1. Байршил: Үйлдвэрлэлийн технологийн хэрэгцээний усыг Туул голоос 2.5. км-ээс татна.

2.4.2. Барилга байгууламж: Ус хуримтлуулах, тунгаах 30000 м³ эзлэхүүнтэй сантай.

2.4.3. Тоног төхөөрөмжийн нэр, марк: Скрин-80 маркийн 1 угаах төхөөрөмжтэй.

2.4.4. Насосны хүчин чадал: Туул голоос D-160, эргэлтийн нуураас ДНУ-160 маркийн насосоор угаах төхөөрөмж рүү ус шахна.

2.5. Хаягдал усны хэмжээ, стандартын шаардлага: Тунгаах нуурын усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэхдээ MNS4943:2015 стандартын шаардлагыг мөрдлөг болгоно.

сны эх үүсвэрэйд хамгаалах, усны нөөц хомдох, бохирдохоос сэргийлэх врв хэмжээ, нд зарцуулах хөрөнгийн хэмжээ; Усны тухай хуулийн 13.1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх илгоор Туул голын хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх ажилд 1.5 сая төгрөг зарцуулна.

.9. Усны тоолуур: Усны тухай хуулийн 30.1.4 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Туул голоос ус татаж буй насосны гаралтанд 2017 оны 6 дугаар сарын 10-ны дотор тоолуур суурилуулна.

2.9.1. Уурхайн үйл ажиллагаа эхлэх үеийн тоолуурын заалт болон сар бурийн сүүлийн өдрийн тоолуурын заалтыг тогтол авч, фото зургаар баталгаажуулан жилийн эцсээр ус ашиглалтын тайланд хавсаргана.

2.9.2. Тоолуурын ажиллагаа доголдсон болон тоолуургүй эх үүсвэрээс ус ашигласан нөхцөлд угаасан элсний хэмжээг уулын ажлын тайланг үндэслэн Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-ын дагуу ашигласан усны зарцуулалтын хэмжээг тооцно.

2.10. Ус ашигласны төлбөрийн хэмжээ:

2.10.1. Урьдчилсан байдлаар нөхөн сэлбэлтээр ашиглах 90'240 м³ усны нөөц шигласны төлбөрт 21'530'361 /хорин нэгэн сая таван зуун гучин мянга гурван зуун жаран зг/ төгрөг, зам талбайн усалгаанд ашиглах 4680 м³ усны нөөц ашигласны төлбөрт 372'200 урван зуун далан хоёр мянга хоёр зуу/ төгрөг, нийт 21'902'561 /хорин нэгэн сая есөн зуун зёр мянга таван зуун жаран нэг/ төгрөгийг Булган аймгийн Төрийн сан банкны 040000944 ют дансанд төвлөрүүлнэ. Төлбөрийн 20 хувийг хоёрдугаар, 40 хувийг гуравдугаар, 40 хувийг дөрөвдүгээр улиралд төлнэ.

2.10.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 23 гаар зуйлийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу усны төлбөрийг төвлөрүүлэхдээ тоолуурын заалтыг үндэслэн ус ашиглуулах дүгнэлтээр тогтоосон төлбөрийн хувь хэмжээгээр орлогыг сараар сарын 10-ны өдрийн дотор төлж барагдуулна.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2. Ус ашиглагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Усны тухай хуулийн 9, 29.3 дугаар заалтуудыг үндэслэн Сав газрын захиргааны шийдвэрээр гэрээг даанаас нь өмнө цуцлах бөгөөд Усны тухай хуулийн 33.1.10, 33.1.12, 33.1.13, 33.1.14, 15, 33.1.16 дахь заалтын дагуу хариуцлага хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.


4.3. Ус ашиглуулагч нь 2017 оны 12 дугаар сарын 20-ны дотор ус ашиглалтын нг хүлээн авч, 2 тал гэрээний биелэлтийг ажлын 10 хоногт багтаан дүгнэж, тэмдэглэл гарын үсэг зурж баталгаажуулна.

- 4.4. Талуудын тохиролцсоноор гэрэнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ.
- 4.5. Талуудын хооронд үүссэн маргааныг зөвшилцэлийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд гэрээ болон түүний аль нэг заалттай холбоотой асуудлаар зөвшилцэлд хурч чадаагүй тохиолдолд асуудлыг холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААГ
ТӨЛӨӨЛЖ:

Ус ашиглалтыг зохицуулах албаны
дарга

 /Ю.Сувдчимэг/

Мэдээлэл, хяналт үнэлгээний албаны
дарга


 /Б.Оюунболд/

Ус ашиглалтыг зохицуулах албаны уул
үүрхай, эрчим хүчний ус ашиглалт
хариуцсан ахлах мэргэжилтэн

 /С.Сүхбат/

"ХҮСЛЭМЖ" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Захирал



/Д.Ганзориг/

Хаяг. Улаанбаатар хот, Баянгол
дүүргийн 14-р хороо, 3-р хороолоп, 10-11
тоот

Харилцах утас: 99114724, 99777069,
99575067, 70009977

аяг: Улаанбаатар хот-16050, БГД,
-р хороо, Чингүнжавын гудамж,
гүл голын сав газрын захиргааны
түр, 2 дугаар давхар, 203 тоот өрөө
харилцах утас: 363716, 363714, 362592